

КАЛИФОРНИЙН ИХ СУРГУУЛЬ, САН ФРАНЦИСКО ХОТ ТУРШИЛТАД ОРОЛЦОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ

Доорх эрх судалгаанд хамрагдахыг хүссэн хүн бүрийн эрх юм. Туршилтад оролцогч би дараах эрхтэй:

- 1) Судалгаагаар юу олж мэдэхийг хүсэж буйг мэдэх,
- 2) Надад юу тохиолдох, аль нэг ажилбар, эм, эсвэл төхөөрөмж стандарт практикт ашиглаж буйгаас ялгаатай эсэхийг мэдэх,
- 3) Судалгааны зорилгоор надад тохиолдож болох нийтлэг ба/эсвэл чухал эрсдэл, гаж нөлөө, зовуурийн талаар мэдэх,
- 4) Судалгаанд оролцсоноор ямар нэгэн ашиг тус хүртэх боломжтой эсэх, хэрэв тийм бол ямар ашиг тус хүртэх боломжтойг мэдэх,
- 5) Надад байгаа бусад сонголтууд, тэдгээр нь судалгаанд оролцохоос дээр эсвэл доор байж болох талаар мэдэх,
- 6) Судалгаанд оролцохыг зөвшөөрөхөөс өмнө болон судалгааны явцад судалгаатай холбоотой аливаа асуулт асуух эрхтэй байх,
- 7) Ямар нэгэн хүндрэл үүсэх тохиолдолд ямар төрлийн эмчилгээ хийлгэх боломжтойг мэдэх,
- 8) Судалгаа эхэлсний дараа оролцохоос бүрмөсөн татгалзах эсвэл оролцох тухай бодлоо өөрчлөх. Энэ шийдвэр нь хэрэв би судалгаанд хамрагдаагүй байсан бол миний авах байсан тусламж үйлчилгээний эрхэд нөлөөлөхгүй.
- 9) Гарын үсэг зурсан, огноотой зөвшөөрлийн маягтын хуулбарыг авах,
- 10) Судалгаанд оролцохыг зөвшөөрөх эсэхээ бодолцох үед дарамт шахалтаас ангид байх.

Тухайн судалгааг Хүнс, Эмийн Захиргаа (ХЭЗ) зохицуулж буй эсэхийг миний судалгааны эмч надад хэлнэ. Хэрэв энэ судалгааг ХЭЗ зохицуулж байгаа бол Хүнс, Эм, Гоо Сайхны тухай Холбооны Хуулийн (ХЭГСТХХ) дагуу ХЭЗ миний судалгаанд оролцохтой холбоотой бүх мэдээллийг шалгаж, хуулбарлах боломжтой гэдгийг би ойлгож байна.

Хэрэв танд өөр асуулт байвал судлаач эсвэл судалгааны туслахаас асуух хэрэгтэй. Түүнчлэн та судалгааны төсөлд оролцогчдыг хамгаалах асуудлыг хариуцсан Байгууллагын Хяналтын Зөвлөл (БХЗ)-тэй холбоо барьж болно. Даваа-Баасан гарагт 8:00-17:00 цагийн хооронд (415) 476-1814 дугаарт холбогдон БХЗ-ийн албатай холбоо барьж эсвэл UCSF Human Research Protection Program, Box 1288, 490 Illinois Street, Floor 6, San Francisco, CA 94143 хаягаар захиа бичиж эсвэл irb@ucsf.edu хаяг уруу э-мэйл илгээн UCSF Хүний Судалгааны Хамгаалах Хөтөлбөртэй холбоо барих боломжтой. Орчуулгын талаарх мэдээллийг (415) 476-1814 дугаарт залгаж эсвэл irb@ucsf.edu хаяг уруу э-мэйл бичиж авна уу.

Зөвшөөрлийн элементийг амаар танилцуулсан.

Оролцогчийн нэр

Оролцогчийн зөвшөөрлийн гарын үсэг

Эцэг эх эсвэл Хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч

Гэрчийн гарын үсэг

Огноо